

## **“ШИЛДЭГ ЗАЛУУ ИНЖЕНЕР” НОМИНАЦИЙН ЭЗНИЙГ ТОДРУУЛАХ ШААРДЛАГА**

### **Нэг. ШАГНАЛЫГ МЭДҮҮЛЭХ**

1.1. Шилдэг залуу инженер шагналыг холбооны олон нийт, дотоод үйл ажиллагааны зөвлөл шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, ажлын үзүүлэлт, судалгаа, тооцоогоор баталгаажуулан, нээлт бүтээлийн жагсаалтыг хуулбарлан хавсаргана.

1.2. Шагнуулах саналыг тухайн байгууллагын удирдлагын болон нийт хамт олны хурлаар хэлэлцэх ба шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, ажлын үзүүлэлт, судалгаа, тооцоогоор баталгаажуулан, нээлт бүтээлийн жагсаалтыг хуулбарлан хавсаргана. Дараах материалуудыг бүрдүүлж холбоонд хандана.

- 1.2.1. Тухайн байгууллагын албан бичиг
  - 1.2.2. Шагналд нэр дэвшүүлсэн хүний анкет, үндэслэл, фото зураг
  - 1.2.3. Хамт олны хурлын протокол
  - 1.2.4. Тухайн хүний ажил байдлын тодорхойлолт, бүтээлийн жагсаалт
  - 1.2.5. Шагналд тодорхойлж буй хүнийг МГФЗЗХ-ны шагнагдах шийдвэр гарсны дараа тухайн байгууллагаас үндсэн цалинтай тэнцэхүйц болон дүйцэхүйц шагнал урамшуулал олгохыг зөвшөөрсөн захирлын тушаал
  - 1.2.6. Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар
  - 1.2.7. Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар
- 1.3. Шагналд нэр дэвшүүлж буй хүний бүрдэл болсон материалыг хүлээн авснаар МГФЗЗХ тухайн хүний өмнө ямар нэг үүрэг хүлээхгүй.

1.4. Шагналд нэр дэвшигчийн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд шагнал олгохгүй.

### **Хоёр. ШАГНАЛ ОЛГОХ БОЛЗОЛ**

2.1. Ирүүлсэн мэдүүлгүүдийг хянан үзэж доорх дэс дарааллаар үнэлэмжийг гаргаж “ШИЛДЭГ ЗАЛУУ ИНЖЕНЕР” номинацийн эзнийг тодруулна. Эхний үзүүлэлтээрээ тэнцсэн инженерүүдийн дараагийн үзүүлэлтүүдээр оноо өгч шалгаруулна.

- 2.1.1. Улс, олон улсын хэмжээнд онцгой амжилт гаргасан
- 2.1.2. Салбартаа үнэтэй хувь нэмэр оруулсан, ажлын өндөр амжилт бүтээл гаргасан
- 2.1.3. Салбарын нэр хүндийг өндөрт өргөж, олон талт ажлын эн тэргүүн эгнээнд ажиллан, үеийнхнийхээ бахархал, үлгэр дууриалал болон ажилласан
- 2.1.4. Гаргасан амжилт бүтээл нь салбартаа үнэлэгдсэн
- 2.1.5. Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажилд нээлт, ололт гаргасан
- 2.1.6. Бүтээл туурвисан, хянан тохиолдуулсан
- 2.1.7. Шинэ техник, технологийг салбартаа нэвтрүүлсэн
- 2.1.8. Геодези, зураг зүйн чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан
- 2.1.9. Мэргэжсэн инженерийн зэрэг горилсон
- 2.1.10. Сонин сэтгүүлд эх бэлтгэж нийтлүүлсэн, ярилцлага өгсөн
- 2.1.11. 50 саяас дээш үнийн дүнтэй 2-оос доошгүй төслийг ахлан ажилласан.
- 2.1.12. 5-аас дээш жил үр бүтээлтэй ажилласан
- 2.1.13. Мэргэжлээрээ гадаадын сургалт, семинарт хамрагдсан
- 2.1.14. Мэргэжлээрээ дотоодын сургалт, семинарт хамрагдсан
- 2.1.15. Төслийг ахлаж ажилласан